

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Монложистикс Холдинг ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх) 2025 оны 4-р сарын 26-ны өдрийн 11 цаг 00 минутад эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг Лайстрийм ХХК-ийн тусламжтайгаар хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар хүргэв.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн нарийн бичгийн дарга бөгөөд Хурал зохион байгуулах комиссын дарга Ц. Дуламсүрэн хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчидтэй мэндчилэн, хуралд оролцогчдыг танилцуулсаны дараа хурлын дэгийг танилцуулан хурлыг эхлүүлэв.

Хуралд биечлэн оролцсон:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог, багийн ахлагч н.Булган

Хурлын тооллогын комисс:

1. Комиссын дарга, Дотоод аудитор Б.Тамжиддорж
2. Комиссын гишүүн, ИР хариуцсан мэргэжилтэн Б. Үнэнхүү
3. Комиссын гишүүн, нягтлан бодогч Д. Мягмарсайхан

Хурлын нарийн бичгийн дарга:

1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц. Дуламсүрэн

Хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга Б. Тамжиддоржийг хурлын ирцийг танилцуулахыг хүсэв.

Хурлын ирц: Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргахад нийт хуралд оролцох эрхтэй 373,538,822 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 1486 хувьцаа эзэмшигч байснаас хуралд 327,755,750 ширхэг энгийн хувьцаа бүхий 45 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 87.74 хувь болж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож байгааг Хурлын даргад мэдээлэв.

Ирц бүрдсэн тул компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд Хурлын дарга Г. Хишигбат хурлыг нээж үг хэлэн, хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Танилцуулсан нь:

Хурлын дарга Г. Хишигбат хурлын нээж хэлсэн үгэндээ “Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд хэмээх эрхэм зорилгын хүрээнд өргөн цар хүрээтэй, олон талт, амбицтай үйл ажиллагаагаа явуулж буй Монложистикс группын нийт хамт олон болох Монложистикчуудад эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний итгэл, дэмжлэг маш чухал үүрэг гүйцэтгэдэг ба бодит түлхэц болдог гэдгийг цохон тэмдэглэе. Бидний урт хугацааны хамтын ажиллагаа, хүчин чармайлт, итгэлцэл бид бүхнийг олон амжилтанд хүргэж улмаар ирээдүйд үндэстэн дамнасан Монгол брэндийг бий болгоно гэдэгт итгэж байна. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь Монгол улсын макро эдийн засгийн сорилт эхэлж буй, дэлхийн худалдааны тодорхой бус байдалтай, хойд хөршийн зөрчилдөөн үргэжилж байгаа амаргүй цаг үед болж байна. Эдгээр сорилтуудыг амжилттай даван туулахад Монгол улсын тээвэр ложистикийн салбарын инновац, дэд бүтцийн өргөжилт болон өндөр бүтээмжтэй тээврийн шийдэл чухал үүрэг гүйцэтгэх ба улмаар нийт экспортыг биет хэмжээгээр нэмэгдүүлж, импортын өртөгийг бууруулж, дамжин өнгөрөх транзит тээврийг нэмэгдүүлсэнээр бид улсын нийгэм эдийн засагт бодит хувь нэмэр оруулах хариуцлагатай цаг үе ирсэнийг онцлох нь зүйтэй” хэмээгээд компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангаас онцлох тоон үзүүлэлтүүд, үйл ажиллагаа, онцлох хийсэн ажлууд болон санхүүгийн тайлан, тайланд гарсан онцлох үзүүлэлтүүд болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг дэлгэрэнгүй танилцуулж, хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэл өгөөд дэлгэрэнгүй мэдээллийг үйл ажиллагааны тайлангаас танилцах боломжтой гэдгийг тодотгон хэлэв.

Ногдол ашиг тараах тухай болон хувьцаа эргүүлэн халааслах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэр, түүний талаарх мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулав.

Хурлын дарга Г. Хишигбат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулсаны дараа хөндлөнгийн аудитор Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцаж, Г. Хишигбат захирлын танилцуулсан санхүүгийн тайлан бол аудитлагдсан бөгөөд зөрчилгүй гэсэн дүгнэлттэй тайлан гэдгийг баталгаажуулав.

Хурлын дарга Г. Хишигбат Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн №25/ТУЗ/22 тоот тогтоолоор батлагдсан “2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Монложистикс Холдинг ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийж ажилласан "Грант Торнтон

Аудит” ХХК-ийн Хараат бус аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй”, “Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй” гэсэн дүгнэлтийг танилцуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг ТУЗ-ийн 2024 оны тайланг танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт хариулт:

Хувьцаа эзэмшигчдээс дараах асуултууд ирсэнийг танилцуулав.

1. Хувьцаа халааслах хөтөлбөрийн үр дүнд энэ жилийг дуустал өссөн дүнгээр хувьцаа авах нөхцөл бүрдчихлээ гэж бодож байна, зах зээлийн үнийг заавал ингэж өсгөх ямар учиртай вэ? Нэгж хувьцаа 210 ₮ гэхээр IPO-д орсон хүмүүс мөнгөө хадгаламжинд хадгалсан нь дээр юм уу?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Монложистикс Холдинг компанийн ТУЗ-ийн зүгээс хувьцаа халааслах шийдвэрийг гаргасан үндсэн зорилго нь хоёрдогч зах зээл дээр хувьцааны хөрвөх чадвар дэмжих явдал юм. Манай хувьцаа өдрийн 3 сая орчим арилжаалагдаж байсныг дэмжих зорилгоор, өнгөрсөн жил Хас банк хувьцаа халааслах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн, тус банкны хөтөлбөрийн үр дүнг харгалзан үзээд, хувьцаа халааслах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон. 1 тэрбум төгрөгөөр худалдан авна гэж тогтоосон, анх IPO хийхэд нэгж хувьцаа 185 төгрөгөөр арилжиж байсан бол хувьцаа халааслах хөтөлбөрийн үнэ 210 төгрөг гэхээр 13 хувийн өсөлт, мөн өнгөрсөн хугацааны ногдол ашгийг оролцуулаад тооцвол нэгж хувьцааны өгөөж нь 20-22% хувийн өгөөжтэй гарахаар байгаа юм. Энэ нь аль ч банкны хадгаламж, ямар ч бондноос олүү өндөр өгөөж юм, тэгэхээр хадгаламжинд байснаас ашигтай байсан гэж харж болохоор байна. Хувьцааг эргүүлэн худалдан авах дээд үнийг 210 төгрөг гэж тогтоосон нь бүх хувьцааг 210 төгрөгөөр худалдаж авна гэсэн үг биш юм, зарах ханш бага байвал тэр үнээр л аваад явна.

2. Ойрын 5 жилд цэвэр ашгийг хэдэн хувиар өсгөх төсөөлөлтэй байна вэ? Ногдол ашиг энэ жил багассан гэж ойлгож болох уу?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Бид ирээдүйд эздийн өмчийн өгөөжийг 30 хувьд барихаар тооцож байгаа. Хэдийгээр IPO хийх үеийн амлалт дээр бид 20 орчим тэрбум төгрөгийг ашигтай ажиллана гэж төсөөлж байсан ч үүнд хоёр том хүчин зүйл нөлөөллөө. Нэгт 2024 оны 1 дүгээр сарны 1-ний өдрөөс хэрэгжинэ гэсэн хүлээлттэй байсан Төмөр замын тээврийн тухай хууль хойшилсон, өнөөдрийг хүртэл агуулгаараа хэрэгжээгүй байдалтай байна, хоёрт 100 вагоныг 2024 оны 2-р хагас гэхэд үйл ажиллагаанд оруулна гэсэн хүлээлт байсан. Вагоны тухайд өнөөдрийн хуралд дэлгэрэнгүй танилцуулсан, ямартаа ч 2025 оны 2-р улиралд нэг цуваа вагон тээвэрт яваад эхэлнэ гэж харж байна. Энэ хоёр гол хүчин зүйлтэй холбоотой IPO-гийн prospectus хойшилсон, гэхдээ бид өөр олон төслүүдийг хэрэгжүүлэхээр менежментийн баг, группийн компаниудаараа зориод

явж байна. Эдгээр төслүүд хэрэгжээд явбал үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг дээрээ нэмээд 5-6 тэрбумын өсөлтийг бий болгоно гэж харж байна.

Ногдол ашгийн тухайд өнгөрсөн жил 3 тэрбум төгрөгийн буюу нийт цэвэр ашгийн 40 хувь орчмыг ногдол ашиг болгон олгосон бол энэ жил 20 хувь болгож бууруулсан. Гэхдээ компани 2 байдлаар ашгийг хуваарилж байгаа, 2 тэрбум гаруй төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр олгож, 1 тэрбум төгрөгийг хувьцаа халааслах байдлаар нийт 3 тэрбум төгрөгийг хуваарилсан, энэ бол АНУ-ын хөрөнгийн зах зээлд түгээмэл хэрэгжүүлдэг, хувьцаа эзэмшигч нарт өгөөж өгдөг хөтөлбөр юм, бид аль аль хөтөлбөрийг хэрэгжүүлж үзье гэж шийдсэн, цаашид үр дүнг нь харгалзаж байгаад 2025 онд хэрхэн үргэлжлүүлэхээ шийдэх юм.

Санал өгөх зааврыг Хурал зохион байгуулах комиссын дарга Ц. Дуламсүрэн танилцуулж, санал хураалтын 10 минут эхэлснийг мэдэгдэв.

Санал өгөх болон тоолох хугацаа нийт 15 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Б. Тамжиддорж Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар танилцуулав. Хурлаар дараах асуудлыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. “Монложистикс Холдинг ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх” асуудлаар санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
327,079,512	99.997% (мянганы)	0	0%	10,640	0.003% (мянганы)
Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 99.997 хувиар хүчинтэй.					

Хурлын дарга Г. Хишигбат санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэр гарсан тухай танилцуулав. Үүнд:

Шийдвэр 1: “Монложистикс Холдинг” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлав.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д даалгасугай.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлэв.

Хурал 12 цаг 55 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Ц. Дуламсүрэн

Хянасан:

Хурлын дарга

Г. Хишигбат

